

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 08.21 № 25

танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА М.БАНЗААГАЯ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Есөнбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангаас “Зүү эмчилгээний өрөө тохижуулах” зориулалтаар 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Байгууллагын үйл ажиллагааны магадлан итгэмжлэх хугацааг 2 жилээр сунгуулсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс байгууллагын тогтмол зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 126,803.0 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 99,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 27,000.6 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

8225020068

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,750.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, бусад эх үүсвэрээс 9,953.8 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 874,555.3 мянган төгрөгийг нэхэмжилснээс 786,608.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч 28,316.6 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Байгууллагын даргын 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/16 дугаар тушаалаар төлбөртэй өрөөний хоногийн төлбөрийг нэмэгдүүлэн 10.0 мянган төгрөг болгосноор 3,620.0 мянган төгрөгийн орлогыг байгууллагын дансаар дамжуулалгүй бэлнээр хураан зарцуулсан байна.

Бусад асуудал

Тус байгууллага нь төсвийн захирагчийн 4 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 2 арга хэмжээ 80.0 хувь, 36 арга хэмжээ 100.0 хувиар биелж нийт дүнгээр 98.0 хувиар биелүүлж, биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>90,390,563.84</u>	<u>185,872,166.27</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	618,102.35	4,253,692.05
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	618,102.35	4,253,692.05
31110	Төгрөг	618,102.35	4,253,692.05
33	АВЛАГА	45,277,500.00	133,224,093.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	45,277,500.00	133,224,093.72
35	БАРАА МАТЕРИАЛ	44,494,961.49	48,394,380.50
351	Түүхий эд материал	6,801,274.49	6,322,308.50
35130	Эм боох материал	6,801,274.49	6,322,308.50
354	Хангамжийн материал	37,693,687.00	42,072,072.00
35410	Бичиг хэргийн материал	328,000.00	576,710.00
35420	Аж ахуйн материал	33,117,347.00	37,500,984.00
35450	Барилгын засварын материал	-	1,565,000.00
35460	Хүнсний материал	2,018,250.00	279,300.00
35470	Бусад хангамжийн материал	2,230,090.00	2,150,078.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>476,534,244.44</u>	<u>435,386,256.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	476,534,244.44	435,386,256.09
392	Биет хөрөнгө	450,040,244.44	408,892,256.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	417,807,380.00	417,807,380.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(84,095,764.77)	(111,220,964.37)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,000,000.00	24,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,250,000.00)	(8,250,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,387,350.20	93,976,989.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,526,651.72)	(27,740,778.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,976,155.00	35,554,965.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,414,761.84)	(15,272,251.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	897,250.00	897,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(740,712.43)	(860,333.31)
393	Биет бус хөрөнгө	26,494,000.00	26,494,000.00
39301	Програм хангамж	2,859,927.85	2,859,927.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,249,927.85)	(2,249,927.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,884,000.00	25,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>566,924,808.28</u>	<u>621,258,422.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>68,158,318.31</u>	<u>31,595,957.52</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,158,318.31	31,595,957.52
413	Өглөг	68,158,318.31	31,595,957.52
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	16,795,767.16	-
4136	Бусад өглөг	51,362,551.15	31,595,957.52
41361	Байгууллагад төлөх өглөг	51,207,051.15	31,086,157.52
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	155,500.00	509,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>498,766,489.97</u>	<u>589,662,464.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	498,766,489.97	589,662,464.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	523,422,311.67	523,422,311.67
51101	Өмч: - төрийн	523,422,311.67	523,422,311.67
512	Хуримтлагдсан үр дүн	(34,862,781.13)	56,033,193.74
51210	Өмнөх үеийн үр дүн	(34,862,781.13)	(34,862,781.13)
51220	Тайлант үеийн үр дүн	-	90,895,974.87



51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,206,959.43	10,206,959.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>566,924,808.28</u>	<u>621,258,422.36</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	948,333,076.80	1,031,366,182.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,453,476.80	57,008,442.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,453,476.80	57,008,442.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,057,000.00	57,008,442.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,057,000.00	43,004,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	60,396,476.80	14,004,442.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	853,879,600.00	974,357,740.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	99,802,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	99,802,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	853,879,600.00	874,555,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	853,879,600.00	874,555,340.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	980,165,183.34	940,470,207.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	980,165,183.34	940,470,207.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	980,165,183.34	940,204,727.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,871,887.98	567,816,256.96
210101	Үндсэн цалин	303,646,482.18	376,740,761.24
210102	Нэмэгдэл	277,627,046.15	120,552,270.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,617,000.00	13,647,000.00
210104	Урамшуулал	27,981,359.65	56,876,225.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,790,000.00	70,873,711.37
210201	Тэтгэврийн даатгал	50,029,200.00	46,229,211.37
210202	Тэтгэмжийн даатгал	5,690,200.00	6,161,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,552,200.00	3,080,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,138,000.00	3,080,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,380,400.00	12,322,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,150,891.71	112,458,187.95
210301	Гэрэл, цахилгаан	7,426,644.56	6,306,497.04
210302	Түлш, халаалт	61,734,971.15	70,397,114.91
210303	Цэвэр, бохир ус	42,989,276.00	35,754,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,556,482.85	19,173,909.00
210401	Бичиг хэрэг	8,280,180.00	5,620,940.00
210402	Тээвэр, шатахуун	1,339,800.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,984,446.25	2,337,724.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,142,556.60	5,217,812.00
210408	Бараа материал акталсны зардал	5,149,500.00	5,277,433.00
2105	Нормативт зардал	93,380,254.84	93,235,777.99

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,967,774.84	38,349,843.99
210502	Хоол, хүнс	44,828,480.00	53,400,934.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	584,000.00	1,485,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,684,500.00	6,089,400.00
210604	Урсгал засвар	2,684,500.00	6,089,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,770,000.00	5,772,000.00
210702	Дотоод албан томилолт	1,770,000.00	5,772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,151,579.23	7,938,054.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,901,455.23	3,843,480.09
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,724.00	38,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,850,000.00
210807	Газрын төлбөр	129,400.00	129,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,809,586.73	56,847,430.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,877,400.00	2,795,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,932,186.73	53,851,830.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	265,479.42
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	265,479.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	265,479.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(31,832,106.54)	90,895,974.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(31,832,106.54)	90,895,974.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	34,057,000.00	929,415,146.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,057,000.00	43,004,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,057,000.00	43,004,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,057,000.00	43,004,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,057,000.00	43,004,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	886,411,146.28
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	99,802,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	99,802,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	786,608,746.28
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	786,608,746.28
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	864,668,881.86	923,029,556.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	864,668,881.86	923,029,556.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	864,668,881.86	922,764,077.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,076,120.82	584,612,024.12
210101	Үндсэн цалин	286,850,715.02	391,347,528.39
210102	Нэмэгдэл	277,627,046.15	122,741,270.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,617,000.00	13,647,000.00
210104	Урамшуулал	27,981,359.65	56,876,225.17

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,790,000.00	70,873,711.37
210201	Тэтгэврийн даатгал	50,029,200.00	46,229,211.37
210202	Тэтгэмжийн даатгал	5,690,200.00	6,161,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,552,200.00	3,080,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,138,000.00	3,080,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,380,400.00	12,322,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,637,695.56	123,236,920.58
210301	Гэрэл, цахилгаан	7,426,644.56	5,345,021.07
210302	Түлш, халаалт	42,211,051.00	77,421,395.51
210303	Цэвэр, бохир ус	36,000,000.00	40,470,504.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,126,804.61	15,648,874.00
210401	Бичиг хэрэг	6,982,850.00	6,166,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,339,800.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,983,744.61	2,337,724.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,250,410.00	6,424,600.00
2105	Нормативт зардал	66,552,120.00	103,070,923.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,211,810.00	43,118,183.00
210502	Хоол, хүнс	30,178,310.00	58,580,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,162,000.00	1,372,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,418,900.00	9,352,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,500,000.00
210602	Тавилга	-	550,000.00
210604	Урсгал засвар	2,418,900.00	7,302,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,770,000.00	5,772,000.00
210702	Дотоод албан томилолт	1,770,000.00	5,772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,821,280.87	3,863,054.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,571,156.87	3,618,480.09
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,724.00	38,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	129,400.00	129,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,475,960.00	6,333,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,475,960.00	6,133,670.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	265,479.42
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	265,479.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	265,479.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(830,611,881.86)	6,385,589.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,730,000.00	2,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,730,000.00	2,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,730,000.00	2,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,730,000.00	2,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,730,000.00)	(2,750,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(836,341,881.86)	3,635,589.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,357,884.21	618,102.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	618,102.35	4,253,692.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	(34,862,781.13)	498,766,489.97
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	(34,862,781.13)	498,766,489.97
3	Тайлант үеийн үр дүн	-	-	90,895,974.87	90,895,974.87
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,422,311.67	10,206,959.43	56,033,193.74	589,662,464.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Улсын төсөв

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	925,562,000.00	825,977,156.58	99,584,843.42	89.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	925,562,000.00	825,977,156.58	99,584,843.42	89.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,562,000.00	825,977,156.58	99,584,843.42	89.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,676,500.00	584,612,024.12	27,064,475.88	95.58
210101	Үндсэн цалин	416,684,700.00	391,347,528.39	25,337,171.61	93.92
210102	Нэмэгдэл	123,560,900.00	122,741,270.56	819,629.44	99.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,849,100.00	13,647,000.00	15,202,100.00	47.30
210104	Урамшуулал	42,581,800.00	56,876,225.17	(14,294,425.17)	133.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,014,000.00	70,873,711.37	6,140,288.63	92.03
210201	Тэтгэврийн даатгал	52,369,500.00	46,229,211.37	6,140,288.63	88.28
210202	Тэтгэмжийн даатгал	6,161,100.00	6,161,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,600.00	3,080,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,080,600.00	3,080,600.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,322,200.00	12,322,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,700,000.00	23,700,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	16,800,000.00	16,800,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	6,900,000.00	6,900,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,208,600.00	15,648,874.00	14,559,726.00	51.80
210401	Бичиг хэрэг	10,862,000.00	6,166,550.00	4,695,450.00	56.77
210402	Тээвэр, шатахуун	1,356,600.00	0	1,356,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,340,000.00	2,337,724.00	2,276.00	99.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,250,000.00	720,000.00	530,000.00	57.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,400,000.00	6,424,600.00	7,975,400.00	44.62
2105	Нормативт зардал	133,600,300.00	103,070,923.00	30,529,377.00	77.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,789,300.00	43,118,183.00	13,671,117.00	75.93
210502	Хоол, хүнс	70,385,000.00	58,580,240.00	11,804,760.00	83.23

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,426,000.00	1,372,500.00	5,053,500.00	21.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,900,000.00	12,102,900.00	7,797,100.00	60.82
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,800,000.00	3,755,000.00	45,000.00	98.82
210602	Тавилга	0	1,045,000.00	(1,045,000.00)	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0	-	
210604	Урсгал засвар	16,100,000.00	7,302,900.00	8,797,100.00	45.36
2107	Томилолт, зочны зардал	6,596,000.00	5,772,000.00	824,000.00	87.51
210702	Дотоод албан томилолт	6,596,000.00	5,772,000.00	824,000.00	87.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,492,600.00	3,863,054.09	9,629,545.91	28.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,174,700.00	3,618,480.09	4,556,219.91	44.26
210803	Даатгалын үйлчилгээ	115,500.00	54,450.00	61,050.00	47.14
210804	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.00	38,724.00	1,276.00	96.81
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00	11,000.00	66.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	0	5,000,000.00	-
210807	Газрын төлбөр	129,400.00	129,400.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,374,000.00	6,333,670.00	3,040,330.00	67.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,174,000.00	6,133,670.00	3,040,330.00	66.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	200,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	925,562,000.00	829,612,746.28	95,949,253.72	89.63
33	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	890,914,200.00	786,608,746.28	104,305,453.72	88.29
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	890,914,200.00	786,608,746.28	104,305,453.72	88.29
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	34,647,800.00	43,004,000.00	(8,356,200.00)	124.12
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,057,000.00	43,004,000.00	(8,947,000.00)	126.27
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	590,800.00	0	590,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	618,102.35	(618,102.35)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,253,692.05	(4,253,692.05)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	27.50	24.50	3.00	89.09
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.50	23.50	3.00	88.68
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.50	16.50	3.00	84.62
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Орон нутгийн төсөв (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,802,400.00	99,536,920.58	265,479.42	99.7

21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,802,400.00	99,536,920.58	265,479.42	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,802,400.00	99,536,920.58	265,479.42	99.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,802,400.00	99,536,920.58	265,479.42	99.7
210301	Гэрэл, цахилгаан	5,345,021.07	5,345,021.07	0.00	100.0
210302	Түлш, халаалт	60,621,395.51	60,621,395.51	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	33,835,983.42	33,570,504.00	265,479.42	99.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,536,920.58	99,802,400.00	99,536,920.58	100.3
320001	Орон нутгийн төсвөөс	99,536,920.58	99,802,400.00	99,536,920.58	100.3
213403	төвлөрүүлэх шилжүүлэг	0	265,479.42	0	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 112,146.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ 99,802.4 мянган төгрөгийг ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилалаар тайлагнасан.
- Санхүүгийн байдал, үр дүнгийн тайланд тайлант үеийн үр дүнг 1,602.0 мянган төгрөгөөр илүү,
- Үр дүнгийн тайланд хангамж, бараа материалын зардлыг 3,260.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,485.0 мянган төгрөгөөр тус тус илүү, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,136.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,609.2 мянган төгрөгөөр тус тус дутуу,
- Мөнгөн гүйлгээний тайланд эд хогшил, урсгал засварын зардлыг 495.0 мянган төгрөгөөр илүү, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 495.0 мянган төгрөгөөр дутуу,
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмж хандиваар авсан 3,898.8 мянган төгрөгийг худалдан авснаар,
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тээврийн хэрэгсэл худалдан авсан зардлыг 1,602.0 мянган төгрөгөөр илүү, бараа материалын тодруулга тайланд барилгын засварын материал худалдан авсан зардлыг 1,602.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 9,032.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



Аудитаар нийт 9,032.2 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 134.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 134.8 мянган төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

2. Байгууллагын даргын шийдвэрээр төлбөртэй өрөө ажиллуулан 3,620.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн дансаар дамжуулалгүй бэлнээр хураан авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын хавсралт "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1дүгээр зүйлийн 1.4-т "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ", 6.1-т "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлнээр мөнгө хураан авч байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 5,277.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүй хөрөнгө акталсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 37,894.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй байхад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд худалдан авах ажиллагаа зохин байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,109,102.3 мянган төгрөгийн 59 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлогын гүйлгээний 109,206.4 мянган төгрөгийн төгрөгийн 5, зарлагын 50,288.8 мянган төгрөгийн 5 мэдээллийг тус тус мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" , 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" , 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлэх зөвлөмж хүргүүлсэн.

2. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 28,316.6 мянган төгрөг хасагдсан байна. Энэ нь системийн программаас 6,815.6 мянган төгрөг, эмч, эмнэлэгийн мэргэжилтгүүдийн үйл ажиллагаанаас 21,501.0 мянган төгрөг тус тус хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1.даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"; 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТААР
2024

баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх"-тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүжилтийг бүрэн авах, хасагдлын хэмжээг бууруулан ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй	
										Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
	Мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ 99,802.4 мянган төгрөгийг ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилаалаар тайлагнасан.	1	99,802.4	-	-	1	99,802.4	1	99,802.4	-	-	-	-
	Санхүүгийн байдал, үр дүнгийн тайланд тайлант үеийн үр дүнг 1,602.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	1,602.0	-	-	1	1,602.0	1	1,602.0	-	-	-	-
Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлэг	Үр дүнгийн тайланд хангамж, бараа материалын зардлыг 3,260.8 мянган төгрөгөөр, норматив зардлыг 1,485.0 мянган төгрөгөөр тус тус илүү, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,136.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,609.2 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	4,745.8	-	-	1	4,745.8	1	4,745.8	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд эд хогшил, урсгал засварын зардлыг 495.0 мянган төгрөгөөр илүү, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 495.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	495.0	-	-	1	495.0	1	495.0	-	-	-	-
	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмж хандиваар авсан 3,898.8 мянган төгрөгийг худалдан авснаар тайлагнасан.	1	3,898.8	-	-	1	3,898.8	1	3,898.8	-	-	-	-
	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тээврийн хэрэгсэл худалдан авсан зардлыг 1,602.0 мянган төгрөгөөр илүү, бараа материалын тодруулга тайланд барилгын засварын материал худалдан авсан зардлыг 1,602.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,602.0	-	-	1	1,602.0	1	1,602.0	-	-	-	-
Дүн		6	112,146.0	-	-	6	112,146.0	6	112,146.0	-	-	-	-



4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:													
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн							
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
	Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 134.4 мянган төгрөгийг илүү олгосон.	1	134.80	1	134.80	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Байгууллагын даргын шийдвэрээр төлбөртэй өрөө ажиллуулан 3,620.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн дансаар дамжуулалгүй бэлнээр хураан авч зарцуулсан байна.	1	3,620.00	-	-	1	1,880.40	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 5,277.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсан.	1	5,277.40	-	-	1	5,277.40	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлэг	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 37,894.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй байхад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авсан байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 28,316.6 мянган төгрөг хасагдсан байна. Энэ нь системийн программаас 6,815.6 мянган төгрөг, эмч, эмнэлэгийн мэргэжилтгүүдийн үйл ажиллагаанаас 21,501.0 мянган төгрөг тус тус хасагджээ.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
	Дүн	5	9,032.2	1	134.8	3	8,897.40	1	-	-	-	1	-	-	-	-	-



/мянган төгрөгөөр/

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн											
		Үүнээс:											
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн					
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Уламжлалт Анагаах Ухааны Нэгдсэн Эмнэлгийн	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,109,102.3 мянган төгрөгийн 59 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлогын гүйлгээний 109,206.4 мянган төгрөгийн төгрөгийн 5, зарлагын 50,288.8 мянган төгрөгийн 5 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-		
Нийт		1	-	-	-	-	-	1	-	-	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах				Санал дүгнэлт гаргасан			
		Түвшрэт хамруулсан		Аудит хийгээгүй		Өөрчлөлтгүй		Хязгаарлалттай	
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	1	1	1	1	1	1
НИЙТ		1	1	1	1	1	1	1	1

